

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2018 оны 4 сарын 17-ны өдрийн А/03 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Дашинчилэн сумын Бүрэн дунд сургуулийн 2016, 2017 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд 2018 оны 4 сарын 24-ны өдрөөс 6 хоног шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бүрэн дунд сургуулийн 2016, 2017 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, зарцуулалт, дотуур байр болон үдийн цай хөтөлбөрийн хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Дашинчилэн сумын 4-р багт байрлах Бүрэн дунд сургууль нь 2016-2017 оны хичээлийн жилд 521-535 суралцагчид суралцсан.

2016, 2017 онд сумын засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/06 тоот захирамжаар захирал, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан, нярав, номын санч, сургуулийн эмч, багш 31, дотуур байрны багш, архивын бичиг хэргийн ажилтан, хоол зүйч, тогооч 3, угаагч 2, үйлчлэгч 4, дотуур байрны жижүүр 4, сахиул 1, слесарь 1, галч 8 нийт 65 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2016 оны 01 сарын 01-ээс 2017 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл Ю.Цогмандах, 2016 оны 1 сарын 1-ээс 3 сарын 31-ны өдрийг хүртэл 2-р гарын үсгийг С.Оюумаа, 2016 оны 4 дугаар сарын 01-ны өдрөөс 2017 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл Р.Билгүүнмаа нар зурсан ба төрийн санд бүртгэлийн 100040515101 тоот, нэмэлт санхүүжилтийн 100040515401 тоот, ХАА-н банкинд байрших бэлэн мөнгөний 5276140276 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох "СТS" программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус сургуулийн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь түүвэрт хамрагдсан тул дүгнэлт гараагүй. 2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан түүвэрт орсон тул дүгнэлт гараагүй байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бүрэн дунд сургуулийн 2016, 2017 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт, 2016, 2017 оны санхүүгийн тайлан, дотуур байрны суралцагчдын ирцийн бүртгэл, 2016, 2017 оны хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хөдөлмөрийн дотоод журам зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал Ю.Цогмандах, нягтлан бодогч Р.Билгүүнмаа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2016 онд улсын төсвөөс мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, 756165.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансны 4914.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 13526.9 мянган төгрөг бүгд 774607.4 мянган төгрөгний эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2016 онд төсөвт зардлыг 752404.9 мянган төгрөгнийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 752404.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажиллагсадтай холбоотой зардалд 503958.9 мянган төгрөг, ндш-д 55498.5 мянган төгрөг, тогтмол зардалд 56754.8 мянган төгрөг, нормативт зардал 31216.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3732.8 мянган төгрөг, БҮТЭЗ 1949.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 3923.7 мянган төгрөг, томилолтын зардал 323.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардал 838.5 мянган төгрөг, ЖА тэтгэмж 13526.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 5063.6 мянган төгрөг, үдийн цай 23408.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвортой ажилласан 13448.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгө оруулалтаар

тоног төхөөрөмж 22202.5 мянган төгрөг үлдэгдэл 38761.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

2017 онд улсын төсвөөс 807187.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 807187.9 мянган төгрөгийг авч, нийгмийн даатгалын сангаас 13684.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны 5802.5 мянган төгрөг бүгд 826675.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2017 онд төсөвт зардлыг 807187.9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 823466.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажиллагсадтай холбоотой зардалд 503944.7 мянган төгрөг, ндш-д 56824.8 мянган төгрөг, тогтмол зардалд 48196.2 мянган төгрөг, нормативт зардалд 30358.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 4396.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 6430.8 мянган төгрөг, албан томилолтын зардалд 310.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 889.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11118.9 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох, тэтгэмжид 62012.4 мянган төгрөг, үдийн цай 12712.5 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 23031.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 19500.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалт тоног төхөөрөмж 3208.8 мянган төгрөг, үлдэгдэл 17417.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн 100040515401 тоот дансаар БСШУЯ-наас хэрэгжүүлж буй стем 1,2 хөтөлбөрийн хүрээнд төслийн сонгон шалгаруулалтаар 5802.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирснээс 1150.5 мянган төгрөгийг сургалтын зардалд, 4652.0 мянган төгрөгийг бага ангийн сурагчдад сэтгэн бодох чадвар хөгжүүлэх 167 нэр төрлийн 167 ш тоглоом авахад зарцуулсан байна.

Цалин урамшууллын талаар:

2017 онд сургуулийн захирлын 2017 оны 03 сарын 22-ны өдрийн Б/12 тоот тушаалаар 64 ажилтанд 38-45%-иар 10548.3 мянган төгрөг, мөн оны 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн Б/13 тоот захирлын тушаалаар аймгийн аварга шалгаруулах самбо бөхийн тэмцээнээс сурагчид нь амжилт үзүүлсэн багш Ж.Цолмонбаатарт цалингийн 20% 231.1 мянган төгрөг, 2017 оны 06 сарын 21-ны өдрийн Б/23 тоот тушаалаар 65 багш ажилтанд 20-45%-иар 9326.8 мянган төгрөг, 2017 оны 09 сарын 25-ны өдрийн Б/33 тоот тушаалаар 55 багш ажилтанд 17-40%-иар 5600.8 мянган төгрөг, 2017 оны 12 сарын 18-ний өдрийн Б/55 тоот тушаалаар багш ажилтанд 15-45%-иар 11127.3 мянган төгрөг нийт 36834.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.

Сургуулийн захирал нь аймгийн Засаг даргын 2017 оны 4 сарын 11-ны өдрийн А/200 дугаар захирамжаар ур чадварын нэмэгдэл 20% иар 642.3 мянган төгрөг, 1-р улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг Аймгийн Засаг даргын 2017 оны 04 сарын 25-ны А/238 дугаар захирамжаар 45%-иар 321.3 мянган төгрөг, 2-р улирлын урамшууллыг 2017 оны 07 сарын 20 -ны А/391 дүгээр захирамжаар 45%-иар 321.3 мянган төгрөг, 2017 оны 10 сарын 11-ны А/512 дүгээр захирамжаар 39%-иар 278.4 мянган төгрөг, 2017 оны 12 сарын 21-ны А/634 дугаар захирамжаар 39%-иар 278.4 мянган төгрөг нийт 1199.4 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон. Аймгийн Засаг даргын 2017 оны 04 сарын 11-ны А/200 дугаар захирамжаар ур чадварын

нэмэгдэл 20%-иар 856.8 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2017 оны 10 сарын 11-ны А/514 дугаар захирамжаар ур чадварын нэмэгдэл 15% -иар 412.9 мянган төгрөг тус тус олгосон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	245781600.00	164675607	0	2617457207.00
2	Авто тээврийн хэрэгсэл	20000000.00	0	0	20000000.00
3	Машин тоног төхөөрөмж	155668541.00	10529569.00		166198110.00
4	Тавилга, эд хогшил	123479635.38	4958900.00		128438535.88
5	Номын фонд	6614000.00			6614000.00
6	Батлан хамгаалах тоног төхөөрөмж	18568292.50	108000.00		18676292.50
7	Биет бус хөрөнгө				
8	Бусад үндсэн хөрөнгө				
	Дүн	2759112068.88	180272076.00		2939384144.88

2017 оны эхэнд 2759112.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр дотуур байранд 539.9 мянган төгрөгөөр телевизор, угаалгын машин 350.9 мянган төгрөг, жижүүрийн кабен 1050.0 мянган төгрөг, технологийн кабинетад төмөр шкаф 320.0 мянга төгрөг, 3 ширхэг төмөр шкаф 840.0 мянга төгрөг, 108.0 мянган төгрөгний ном нийт 3208.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авсан. ДЗОУБ-аас компьютер чихэвч 1212.2 мянган төгрөг, БСШУЯ-аас сүлжээний төхөөрөмж 8426.5 мянган төгрөг, номын тавиур 2748.9 мянган төгрөг, улсын төсвөөс хичээлийн 1р байрны дээврийн засвар 164675.6 мянган төгрөгийн хөрөнгө орлогдож жилийн эцэст 2939384.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал				
2	Бэлэн бүтээгдэхүүн	33578.7	24127.7	11909.3	45797.2
3	Аж ахуйн материал	2970.0	29857.5	24367.5	8460.0
4	Тусгай зориулалтын материал	20161.5	4748.2		24909.7
5	Дуусаагүй үйлдвэрэл	1237.7			1237.7
6	Барилгын засварын материал	10990.0	4375.0	10245.0	5120.0
7	Түлш шатах тослох	8844.8	50085.1	49790.8	9139.0
8	Бусад хангамжийн				

материал				
НИЙТ ДҮН	77782.7	113193.5	96312.6	94663.6

2017 оны эхэнд 77782.7 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 101757.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БСУГ-аас 4748.2 мянган төгрөгний багаж хэрэгсэл материалд орлого авч, 96312.6 мянган төгрөгийн материал зарлагдаж 94663.6 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

6.4 Шилэн дансны талаар: 2017 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 119 мэдээллийг хугацаанд нь 31 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Сумын Засаг даргын 2016 оны 01 сарын 21-ны өдрийн Б/12 тоот захирамжаар ур чадварын мөнгө 142794 төгрөг илүү олгосон.

2. Хүнсний болон бусад бараа материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй, орлого зарлагын баримт болон шаардах хуудсанд нягтлан бодогч гарын үсэг зурдаггүй.

НАЙМ. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

1. 2016, 2017 оны санхүүгийн баримтын анхан шатны бүрдэлийг сайн хангасан эмх цэгцтэй үдэгдэж архивлагдсан.

2. Санхүүгийн тайлан мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж тушаадаг

3. Санхүүгийн албанаас дотоод хяналтыг сайн хэрэгжүүлсэн.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Зөрчил дутагдалыг арилгах зорилгоор 142794 төгрөгийн акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 2 албан тушаалтанд арга зүйн зөвлөгөө өгөв.

ЕС. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтуудын хэрэгжилт хангалтгүй.

Санхүүгийн албаны дотоод хяналт сайн байна.

АРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Засгийн газрын 393 дугаар тогтоол, БСШУЯ-ны сайдын 293 дугаар тушаал, Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ Л.ЦЭРЭНБҮТЭД